



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠔ оны ᠐᠕ сарын ᠐᠒ өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, орон сууц болон гэр хорооллын ил задгай ашиглалтгүй болсон кабель, харилцаа холбооны сүлжээний утсыг цэвэрлэх ажлыг зохион байгуулсугай.

2.Тус ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т, Монголын цахилгаан холбоо ХК (Л.Өлзийжаргал)-д, Улаанбаатар төмөр замын дохиолол холбооны 2-р анги Багахангай хэсэг (Э.Бат-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Ажлын явцыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД